

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2-4
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ	6
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨТВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	7-13
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15-15
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ДОЛОО. БИОЛОГИЙ ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ЕС. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГАЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	19-20
АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
Хүснэгт№-4 Галын аюулын үед шуурхай авах арга хэмжээ.....	23
Хүснэгт№-5 Галын аюулын үед татан оролцуулах техник тоног төхөөрөмжүүд.....	24
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25-26
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
АРАВ ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
АРВАН ТАВ. “ТЭРБУМ МОД” ТАРИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР	29
АРВАН ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	30

Хавсралтаар: 2023 онд хийгдсэн соруулах зориулалттай нүхэн ариун цэврийн байгууламж, ахуйн болон техникээс гарсан хаягдалын ангилан ялгах цэг, ангилсан байдлыг оруулж өглөө.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: ӨВӨРЧУЛУУТЫН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АШИГЛАЛТЫН СИСТЕМЭЭР АШИГЛАХ ТӨСӨЛ

Төсөл хэрэгжүүлэгч: “БАЯЛАГ-ОРД” ХХК

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV – 000222 А

Тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ: 72.0 гектар

Талбайн булангийн солбицолууд:

Булангийн цэгийн дугаар	Өргөрөг, N	Уртраг, E
1.	46° 22' 19,28”	100° 07' 46,31”
2.	46° 21' 55,96”	100° 07' 45,83”
3.	46° 21' 56,42”	100° 06' 59,05”
4.	46° 21' 19,75”	100° 06' 59,53”

"Баялаг орд" ХХК нь Дэд бүтцийн сайдын 1997 оны 9-р сарын 19 - ны өдрийн 219 тоот ашигт малтмалын ордыг ашиглуулах тусгай зөвшөөрлийн дагуу 1997 оноос нүүрс олборлож эхэлсэн. Энэхүү нүүрсний ордыг ашиглахын тулд 1999 оноос байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэж байсан ба 2014 онд төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын хуулийн хүчинтэй хугацаа дуусгавар болж одоо 2021 онд “ЭХО-ПАЛАНЕТ” ХХК-наар хийлгэсэний дагуу тухайн жилийн Байгаль орчины менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Уурхайн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллахын тулд уурхайн цахилгаан хэрэглэгчдийг аймгийн эрчим хүчний системд холбох зорилгоор Баянхонгор аймгаас Галуут сумруу татсан 15 КВт - ын агаарын шугамаас салаалуулан Өвөрчулуутын орд хүртэл 18км урттай 15 КВт - ын агаарын шугамыг барьж байгуулсан. Энэхүү 15 КВт - ын агаарын шугамаар уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Өвөрчулуутын хүрэн нүүрсний ил уурхайн үндсэн цахилгаан хэрэглэгчид нь ил уурхайн засварын газар, уурхайн гэрэлтүүлэг, ажилчдын байр, гуанз, уурхайн захиргаа, уурын зуух, шатахуун түгээгүүр байх бөгөөд эдгээр уурхайн цахилгаан хэрэглэгчид нь 0.4 КВт - ын цахилгаан эрчим хүчээр хангагдсан.


Уурхайн тосгон

Зураг №-1



Уурхайн газар зүйн байршилн тойм зураг

Зураг №-2



1.1. Газрын гадарга, усан сүлжээ : Тус район нь далайн түвшинээс дээш хангайн нурууны баруун өмнөд хэсгийн 2370 – 2390 м - н өндөрт оршдог ба рельефийн үнэмлэхүй өндөр баруун хойноос зүүн урагш налуутай 2600 – 2100 м хүртэл буурдаг. Тухайн орчимд өндөр цэг нь Балгант Хайрхан уул 2726.0 м хөндийн дунд хэсэгт 2390.0 м өндөртэй байдаг ба элэгдэлд сайн орсон мөлгөр гадаргуутай уулс зонхилно. Усан сүлжээ муутай байнгын устай гол байхгүй, гандуу уур амьсгалаас шалтгаалан өвслөг ургамалын бүрхүүл муутай.

1.2. Цаг агаар: Талбай нь эх газарын эрс тэс уур амьсгалтай, орон нутгийн цаг уурын станцын мэдээллээс үзэхэд хамгийн хүйтэн үе нь өвлийн 1 - р сард - 40⁰С, хамгийн халуун үе нь зуны 7 - р сард +25⁰С юм. Жилд унах хур тунадасны хэмжээ харилцан адилгүй бөгөөд ихэнх тунадас зуны улиралд 6, 7 - р сард (35 - 90%) унадаг. Жилийн нийт хур тунадасны хэмжээ ойролцоогоор 280мм, зуны улирал харьцангуй богино, намрын улирал урт үргэлжилдэг. Салхины зонхилох чиг нь хойноос урагш бөгөөд хавар, намрын улиралд дээд тал нь 24 м/сек хүртэл салхилдаг.

1.3. Ургамал, амьтны аймаг : Тус районд ой модгүй, ургамлын аймаг жигд биш, огцом өндөрлөг энгэр, ар газраар ургамлын тархац маш бага, нам рельефтэй гадарга Дөвөнтийн хөндийн 2 хажуугийн дэнж, товцогоор олон төрлийн өвслөг, модлог ургамлууд, хялгана бударгана баглуур, хазаар, таана, цахилдаг халгай, дэрс, хамхуул голчлон ургадаг.

1.4. Амьтны аймгийн хувьд чоно, үнэг, хярс, мануул, өмхий хүрэн гэх мэт махчин амьтад тарвага зурам, огтоно, туулай зэрэг мэрэгч амьтад, тас, бүргэд, элээ, хэрээ, шонхор, харцага ногтруу шар шувуу, болжмор, хараацай жигүүртэн шувууд болон төрөл бүрийн хэвлээр явагч амьтад хааяа тохиолддог.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Дэд бүтэц: Тус орон нутагт дэд бүтэц нь харьцангуй сайн хөгжсөн. Хүн амын нягтрал бага гол салбар нь мал аж ахуй юм. Өөр нэг салбар нь алтны уурхайнуудад түшиглэдэг. Баянхонгор аймаг нь газрын байрлалаар өндөрлөг уулархаг газар оршдог усны хагалбар муу тул газар тариалан хөгжөөгүй. Уурхайн талбайгаас 45 км-т оршдог Бөмбөгөр сум нь өндөр хүчдэлд холбогдсон мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дэлгүүр зэрэг үйлчилгээний газруудтай. Уурхайн талбайгаас зүүн хойш 45 км-т Галуут сум орших бөгөөд тус суманд сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, дэлгүүр зэрэг үйлчилгээний газрууд ажилладаг. Энэ сум нь өндөр хүчдэлд холбогдсон. Харилцаа холбооны хувьд МЦХ–ны салбар болон Mobicom, Unitel-ийн үүрэн холбооны сүлжээтэй. Мөн ХААН болон Төрийн банкны салбар үйл ажиллагаа явуулдаг.

2.2 . Зам харилцаа:

Улаанбаатар хотоос Баянхонгор аймаг хүртэл хатуу хучилттай болон сайжруулсан замаар зорчидог Цааш уурхайн талбай хүртэл мөн талбайн хэмжээнд авто тээврээр зорчиход ямар нэгэн бартаа саадгүй авто замын сүлжээ сайн хөгжсөн.

2.3. Харилцаа холбоо:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь харилцаа холбооны бүхий л сүлжээг ашиглах бүрэн боломжтой ба ашиглалтын дотоод үйл ажиллагаандаа гар харилцуурт радио станц ашигладаг болсон. Мөн мобикомын 4G сүлжээ тавигдсанаар дэд бүтэц сайжирсан.

Тус уурхай нь 1997 оноос хойш 25 дах жилдээ олборлотын үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашид 45 жилийн хугацаанд олборлолт явуулах зорилготой байна

2.4 . Уулын ажлын горим: Тус уурхай нь жилийн турш тасралтгүй горимоор ажиллах бөгөөд жилдээ нийт 300 хоног бүрэн хүчин чадлаараа ажиллаж, бусад хугацаа нь баярын амралт болон болзошгүй үед зарцуулагдахаар төлөвлөсөн. Уурхайн ажилчид 2 ээлжээр ажиллах ба нэг ээлжийн ажиллах хугацаа 8-10 цаг байна. Хээрийн нөхцөлд 14 хоног ажиллуулж, 14 хоног гэрт нь амраах байдлаар бахтын системээр ажиллана.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛТ

3.1. Агаарын чанар:

Уурхайн үйл ажиллагааны үед, хөрс хуулах, нүүрс олборлох болон тээвэрлэх техникийн үйл ажиллагааны үед үүсэх хорт хий, тоос тоосонцор тархах, уурхайн кемп, уурхай орчмын хатуу болон шингэн хог хаягдлын цэг, хог хаягдлын шатаалтаас агаар орчинд бохирдол үүсэх, хүнд даацын автомашин явах үед замын хөрс нунтагарч, тодорхой хэмжээний тоос, шороо ойр орчимд тархах нөхцөл бүрдэж байна. Хуурайшилт, салхи ихтэй хавар, намрын улиралд тоос их хэмжээгээр босч, ойр хавийн агаар, хөрсийг бохирдуулах, улмаар хүн ам, мал сүрэгт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Уул уурхайн бүх төрлийн үйл ажиллагаанаас үүссэн тоосонд 1 - 100 микрон диаметр бүхий жижиг ширхэгүүд зонхилдог. Түүнчлэн, уурхайн цооногууд, хог хаягдлын овоолгууд болон хөндөгдсөн нүцгэн газрууд зэрэг нь уурхайн орчинд тоос үүсгэх гол эх үүсвэр болдог. Хэрэв зохистой хяналт тавихгүй бол их хэмжээгээр үүссэн тоос нь гол ус, хөрс болон ургамлан бүрхэвчийг бохирдуулахаас гадна, уурхайн ажилчдын төдийгүй орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд болон хүрээлэх орчны байдалд сөрөг нөлөө үзүүлэх юм. Үүнээс гадна, нарийн тоос, шороо нь уурхайн хүнд машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийн эд ангиудад эвдрэл, гэмтэл учруулж, улмаар үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулж ч болно. Тиймээс төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүний эрүүл мэнд болон байгаль орчинд үүсэж болзошгүй асуудлуудыг хамгийн бага түвшинд байлгахын тулд тоос үүсгэх эх үүсвэрүүдийг цаашдаа уурхайн барилгын инженерийн зураг төсөл, бусад үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд маш нухацтайгаар тусган ажиллаж байна.

3.2. Усан орчин:

Тухайн орд нь гидрогеологийн тааламжгүй нөхцөлд оршдог бөгөөд тус орд орчимд газрын доорхи ус хязгаарлагдмал тархалттай, байнгын урсгалтай гол, горхи болон гүехэн худаг ус байхгүй, гадаргуугийн усан сүлжээ муутай талбай юм. Тухайн талбайн хуурай сайр, хөндийд жилийн дундаж хур тунадас ихтэй үед хөрсний усны шүүрэлт бий болж, бага хэмжээний булаг, шанд илрэх тохиолдол байх бөгөөд сэрүүний улиралд халиа тошин бий болох үзэгдэл мөн ажиглагддаг.

3.3. Хог хаягдал:

Төслийн барилгын ажлын явцад болон ажилчдын байр, ажлын байр, засвар үйлчилгээний хэсэг, агуулах зэрэг бүх ажлын байрнуудаас хатуу, шингэн хог хаягдал гарч байгаа. Жишээлбэл:

- Хатуу хог хаягдал - ахуйн хог хаягдал, хаягдал мод, төмөр, хуучин дугуй, сэлбэг, барилгыг хаягдал г.м,
- Шингэн хог хаягдал - ахуйн бохир ус, ашигласан тос, түлш шатахууны хаягдал г.м. зүйлс орно.

Хатуу хог хаягдал: Уурхайн тосгоны хэмжээнд үүсэх хатуу хог хаягдлыг ахуйн болон машин техникээс сольсон сэлбэг, хэрэгслийн гаралтай хаягдал гэж

хоёр үндсэн хэсэгт хувааж болно. Уурхайн тосгоны ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, гал ажлын байр, агуулах гэсэн үндсэн объектуудаас гарах хог, хаягдлууд орно.

Судалгаанаас үзэхэд уурхайд ажилладаг 1 хүнээс өдөрт дундажаар 1 - 1.5 кг хог хаягдал үүсдэг гэж тооцвол энэхүү төслийн хувьд нийт 24 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 45 кг болж байна. Уурхай жилийн хугацаанд 300 хоног ажиллана гэж тооцвол жилд гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын нийт хэмжээ нь 13.5 тн байна. Уурхайгаас гарах нийт хатуу хог хаягдлийн 10% нь дахин ашиглагдах боломжтой хог байх тул хатуу хог хаягдлыг тухай бүр ангилан ялгаж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ялган цуглуулах, түүнийгээ суурин газарт хоёрдогч түүхий эд авах цэгт борлуулах, үлдэж буй бусад хог хаягдлыг ариутгаж байх, овор хэмжээг нь багасгах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө багатай байхаар тохижуулсан хогийн цэгт хуримтлуулан хаяж, усгаж, улмаар булшилж байгаа. Уг хогийн цэгийг стандартанд нийцүүлэн, төслийн нийт хугацаанд ашиглах хүчин чадалтай байхуйц хэмжээтэй болгож өргөтгөхөөр төлөвлөж байна. Уурхайн хог хаягдлын цэгийг салхины зонхилох чиглэлийн доод талд тогтсон нэг цэгт сонгон байгуулсан тул хүний эрүүл ахуйд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл багасах юм.

3.4. Ахуйн хэрэглээний усан хангамж:

Орд орчмын усанд шинжлэх ухааны академи геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид хийлгэсэн шинжилгээний үр дүнгээр энэхүү ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1 -р төрлийн, давсархаг, хатуу бохирдолтой ус гэсэн тул ахуйн хэрэглээнд шууд хэрэглэхэд тохиромжгүй юм. Иймээс унд ахуйн хэрэгцээний усаа Баянхонгор аймгаас татан хэрэглэнэ.

3.5. Хөрсний эвдрэл, элэгдлээс урьдчилан сэргийлэх болон хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Газар ашиглалтыг оновчтой байдлаар төлөвлөх болон газар ашиглалтын хяналтыг сайжруулж, шаардлагагүй газар ашиглалтыг бууруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Төслийн талбайн дотоод болон гадаад замын маршрутыг тогтоон, шаардлагатай тохиолдолд тоосжилтоос урьдчилан сэргийлж, замыг усалж, олон салаа зам гаргахгүй байх, уурхайн замын хурдны хязгаарыг тогтоож өгөх зэрэг арга хэмжээнүүдийг авч, зохих тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байрлуулсан болно.

3.6. Ургамал ба амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаж буй арга хэмжээ

Ургамал нь устсан болоод чанар нь муудсан газрыг төсөл хэрэгжих явцад боломжтой бол явцын дунд, боломжгүйг нь хаалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үржил шимт хөрсөөр хучиж, бүс нутгийн унаган олон наст ургамлыг тарьж, нутгийн унаган амьтад амьдрах нөхцлийг бүрдүүлэн, бүрэн нөхөн сэргээхээр төлөвлөн ажиллана.


ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Ашигт малтмалыг ашигласан газраа нөхөн сэргээж унаган төрхийг нь эргүүлэн тогтоож, хонхор хотгорыг нь тэгшилж үүсмэл овгор, гүдгэр овоолгыг тэгшилж байгалийн унаган төрхөнд оруулах нь гол зорилт юм.

Тектоник

Г.Бадарч нарын тектоник мужлалын ангиллаар Өвөрчулуутынхүрэн нүүрсний орд нь Баянхонгорын бүс (Зураг 6), О.Төмөртогоо нарын террейны ангиллаар Баянхонгорын террейнд, Ж.Бямба нарын 2012 оны тектоник мужлалын ангиллаар Баянхонгорын хотгорт хамаарагдаж байна. (Монголын геологи ба ашигт малтмал боть-IV).

Монгол орны тектоник мужлалын зураг (Г.Бадарч нар, 2002)



Зураг №-6

Судалгааны талбай нь каледоны атриат мужийн Баянхонгорын заадсын бүсэд багтана. Талбайн дүүргийн тогтоцыг структурын дөрвөн үе шатанд ангилж болно.

Доод үе шатны структур буюу Жаргалантын антиклинори нь одоогийн босоо хяр, өндөрлөгүүдийг үүсгэсэн протерозойн занарын зузаалаг, хоёрдахь үе шатны бүтэц буюу Баянхонгорын синклинори нь доод палеозойн (Кембрий, Ордовикийн) хурдас, гуравдагч буюу Мезозой (доод цэрдийн) хурдас, дээд үе шат буюу Кайнозойн хурдас хуримтлал гэсэн 4 үе шаттай байна.

**Хөрс хуулалт, нүүрс олборлолт нөхөн сэргээлтийн ажилд ажиллах
экскаватор**



Зураг №-7

Экскаваторын техникийн үндсэн үзүүлэлтүүд:

Хүснэгт№-1

№	Үзүүлэлтүүд	Нэгж	HYUNDAI 290LS-7A
1	Шанаганы багтаамж	м ³	1.5
2	Утгалтын хамгийн их радиус	м	11.4
3	Утгалтын хамгийн их гүн	м	7.7
4	Утгалтын хамгийн их өндөр	м	10.6
5	Асгалтын радиус	м	9.8
6	Циклийн хугацаа	сек	20
7	Хөдөлгүүрийн чадал,марк	кВт	169, Cummins QSB6.7
8	Явах анги		гинжит

Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх утгуурт ачигч

Утгуурт ачигч ZL-50-ийн техникийн үзүүлэлт, бүтээл



ZL-50 маркийн утгуурт ачигч

Зураг №-8

ZL-50 маркийн утгуурт ачигчийн техникийн үзүүлэлт:

Хүснэгт №-2

№	үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тэмдэглэгээ	Тоон үзүүлэлт
1	Утгуурын багтаамж	м ³	E	3.0
2	Эргэлтийн радиус	м	r	7.7
3	Ачих хамгийн их өндөр	м	h	2.9
4	Явах ангийн урт	м	E	6.3
5	Явах ангийн өргөн	м	l	2.7
6	Их биений өндөр	м	H	3.5
7	Явах хамгийн их хурд	км/цаг	U	13.4

Дотоод овоолгод хөрс буулгах автосомосмол



Зураг №-9

Автосомосмолын техникийн үзүүлэлт:

Хүснэгт№-3

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	НОРД БЕНЗ
1	Марк		2636K
2	Дугуйн томъёо		8x2
3	Автомашины даац	тн	20
4	Тэвшний багтаамж	м ³	18.4

Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажил нь дотоод овоолгыг түрж тэгшлэх явцад хийгдэх учир уурхайн гадна хураасан үржил шимт хөрсний овоолгоос хөрсийг тээвэрлэн шилжүүлж өрнөлтгүй болсон дотоод овоолго дээр хураасан үржил шимт хөрстэй хамт 0.2 метрийн зузаантайгаар үндсэн хөрсний овоолгын гадаргууг хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлдэнэ.

Үерийн хамгаалалтын далан: Уурхайн орчны байдалтай нь уялдуулан хэлбэржүүлж нөхөн сэргээнэ, шинчлэнэ.

ДОТООД ОВООЛГООР ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ФОТО ЗУРАГ



ЗУРАГ№-18

**УРИД ОНУУДЫН БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ УРГАЦ ХАШАА, ХАЙСЫГ
САЙЖРУУЛАХ ЗУРАГ (хашаажуулсан)**



ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Агаарын чанар	Уурхайн технологийн замыг услаж чийглэж, бүртгэл хөтлөнө.	Уурхайн дотоод тээврийн замуудад	удаа	30 000	12 удаа	360 000	2024 онд Хавар намрын хуурайшилт атай өдрүүдэд	Агаарын тухай хууль шинчлэсэн найруулга 3.1.11 MNS 0012-031:1991, MNS 4990:2000
2.	Гадаргын болон газрын доорх усны нөөц	Гадаргын ил задгай ус тухайн төсөл хэрэгжиж буй газар байхгүй гадаргын хур борооны тогтоол уснаас дээж авч мониторинг хийнэ.	Төслийн талбай болон ойр орчимын гадаргын тогтоол уст цэгүүдэд	ширхэг	100 000	1 дээж	100 000	2024 онд Гадаргын тогтоол уснаас дээжлэлт хийж лаборторд шинжлүүлэн э.	УтХ30.1.1. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;

2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3.	Ургамлан нөмрөг	Ашиглагдсан талбайд биологийн нөхөн сэргээлтийн ургацыг дэмжиж хашаа хайсыг сайжруулна	Төслийн талбай	ширхэг	10	34 000	340 000	2024 онд Кэмп-д 10 ширхэг чацарганы мод нэмж суулгана	БОАЖЯ – ны 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт
	Нийт						800 000		

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК

Өвөр - Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

ЗУРАГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт	га	-	-	-	Тухайн жил төлөвлөөгүй	-
2.	Биологийн нөхөн сэргээлт	төлөвлөөгүй	га	0.5	420 000	2 100 000	2024 оны 6,7 сард	Нөхөн сэргээлтийн ерөнхий шаардлага MNS: 5917:2008
3.	Татан буулгах, хаалтад бэлтгэх	Урид оны биологийн нөхөн сэргээлтийн хашаа хайсыг сайжруулна. Мал орохоос уридчилан сэргийлж	га	-	-	-	Төсөл амжилттай хэрэгжиж байгаа.	50.1.2.ашигт малтмалын тухай хууль эвдэгдсэн газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээнэ.
	Нийт			0.5	420 000	2 100 000		

Хэрэгжүүлэх төлөвлөгөө: “Баялаг - Орд” ХХК Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

ДОЛОО. БИОЛОГИЙ ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Эвдэгдсэн газрын нөхөн сэргээл, тухайн орон нутгийн ургамал салихаар зөөгдөж ирж ургах явцыг бүрдүүлэх	Төслийн талбайн зүүн хойно байрлах “ГӨЛӨГТ” нэртэй газрын эвдэгдсэн 1.0 га талбайн техникийн нөхөн сэргээлт.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлын цар хүрээнд	1.0 га	2 000 000	2 000 000	2024 оны 10 - р сард хийгдэнэ	Техникийн нөхөн сэргээлтийн ерөнхий шаардлага MNS: 5917:2008
2.	Тэр Бум Мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Цөлжилт, бэлчээрийн талхлалтаас уридчилан сэргэийлэх	Тэр Бум Мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	100.0	15 000	1 500 000	2024 оны 10-11 - р сард 100.0 ш цацарганы мод	Мод, модлог ургамал тарих ерөнхий шаардлага MNS 6253-2 : 2011
	Нийт					3 500 000		

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2024 онд 100.0 ширхэг чацарганы суулгац мод тарьж уг хөдөлгөөнд хувь нэмэр оруулахаар төлөвлөлөө.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө хаваржаа өртөх	Манай талбайд, ойр орчим орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө, хаваржаа байдаггүй болно.	Төсөл хэрэгжиж уурхайн хаалт хүртэл	-	-	-	Манай талбайд орон нутгийн иргэдийн хашаа сууц, өвөлжөө, хаваржаа байхгүй болно.	-
	Нийт				0	0		

Тайлбар:

Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрт, түүний ойр орчимд нүүлгэн шилжүүлэх шардлагтай, төслийн нөлөөнд өртөж болзошгүй төв, суурин газар, малчин айл өрх байхгүй болно.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Археологийн дурсгал	Газрын гадарга дээр түүх соёлын дурсгал, өв уурхайн талбайд байхгүй боловч олборлолтын явцад газрын хэвлийгээс гарч үйл ажиллагааны улмаас аюулд өртөж, устаж болзошгүй.	Монгол улсын холбогдох хуулиудын хэрэгжилтийг чанд мөрдөж ажиллана. Олборлолтын явцад археологийн олдвор газрын хэвлийгээс илэрвэл Уурхайн ажлыг түр зогсоож, эрх бүхий байгууллага уудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.	-	-	-	Олборлолтын явцад археологийн олдвор илрээгүй болно. Хэрэв түүх соёлын дурсгалт өв илэрвэл холбогдох байгууллагуудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014.05.15 ний өдрийн шинчилсэн найруулга
2.	Палеонтологийн дурсгал	Олборлолтын явцад газрын хэвлийгээс гарч үйл ажиллагааны	Олборлолтын явцад палеонтологийн олдвор газрын хэвлийгээс илэрвэл	-	-	-	Олборлолтын явцад палеонтологийн олдвор илрээгүй болно. Хэрэв түүх соёлын	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 2014.05.15

2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		улмаас аюулд өртөж, устаж болзошгүй.	уурхайн ажлыг түр зогсоож , эрх бүхий байгууллага уудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.				дурсгалт өв илэрвэл холбогдох байгууллагуудад мэдэгдэж авран хамгаалах арга хэмжээг авна.	ний өдрийн шинчилсэн найруулга
	Нийт				0	0		

Тайлбар:

Төсөл хэрэгжиж буй орчинд ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төсөл хэрэгжих явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээвэл ШУА, Археологи , Палеонтологийн хүрээлэн, Түүхийн хүрээлэн болон орон нутгийн засаг захиргаа холбогдох мэргэжлийн хяналтын газаруудад хандаж авран хамгаалах арга хэмжээг авна.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ил уурхайн аюулгүй ажиллагаа алдагдаснаас осол аваар гарч болзошгүй	Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмийг мөрдлөг болгон ажиллана.	Уурхайн хэмжээнд	1 удаа	50 000	100 000	2024 оны 9 - р сард	Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм ҮХСайдын 2003он 98-р тушаалын хавсралт,
	Нийт			1		100 000		

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөлөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдалыг Галуут сумтай гэрээ хийж хамтран ажиллана.	Уурхайн хэмжээнд	удаа	1 200 000	1	700 000	2024 оны 10-р сард Галуут сумтай хийсэн гэрээний дагуу ачуулна	Хог хаягдалын тухай хууль шинчилсэн найруулга 2017.05.12 ний өдөр 3.1.1
2.	Үйлдвэрийн	Техникээс гарсан хог хаягдалыг Баянхонгор аймгийн хоёрдогч түүхий эд авах цэгт тушаахаар төлөвлөлөө.	Уурхайн хэмжээнд	удаа	100 000	1	100 000	2024 оны 11-р сард өөрийн тээврээр тээвэрлэж Баянхонгор аймгийн “Цэвэр Хот” хоёрдогч түүхий эд авах нэгдсэн цэгт өгнө.	Хог хаягдалын тухай хууль шинчилсэн найруулга 2017.05.12 ний өдөр
								2024 онд Ажилчидын ахуйд хэргэлэх усыг Баянхонгор аймгаас зөөврөөр	

2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3.	Хаягдал ус	Хаягдал ус цэвэршүүлэх дахин ашиглах	Уурхайн хэмжээнд	Тогтмол	Тухай бүрд	Тухай бүрд	500 000	хэрэглэнэ. Хур борооноос тогтсон усыг зумп-д хуримтлуулж биологийн нөхөн сэргээлт, зам талбайн усалгаанд ашиглахаар төлөвлөсөө.	MNS6734:2018
4.	Гал түймэр	Хүрээлэн буй орчинд гал түймэр гарах	Хүрээлэн буй орчиноо хайрлан хамгаалах	Тухай бүрд	Тухай бүрд	Тухай бүрд		Гүйцэтгэх захиралын тушаалаар Бичвэр мэдээллийн 23 – 24 - р хуудсанд орууллаа.	Галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн аж ахуй нэгж байгууллагын хүлээх үүрэг
	Нийт					2	1 300 000		

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК

Өвөр-Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан Б.Баасанжаргал

Тайлбар: Бичвэр мэдээллийн **23 – 24 - р** хуудсанд Галын үед хэрэнжүүлэх төлөвлөгөө, түүнд оролцуулах техник хэргэсэлийг хүснэгтээр орууллаа.

АЮУЛЫН ТӨРӨЛ – ГАЛЫН ҮЕД ШУУРХАЙ АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Өвөр – Чулуутын Нүүрсний ил уурхай

Хүснэгт № 4

Д Д/д	Хийж гүйцэтгэх ажлын арга хэмжээ	Хариуцах эзэн	Ажилтнуудын аюулгүй бүсэд гаргах арга зам, гарц	Аврагчидын явах зам	Аврагчидын гүйцэтгэх үүрэг	Зардал
1.	Уурхайд гал гарсан дохио өгнө	Уурхайн харуул, манаач	Галын цаана байгаа ажилтануудад шүүгч баг, хошуувч зүүлгэж аюулгүйн гарцаар гаргана. Аюулгүйн нөөц гарцаар гаргахдаа хаваж шатсан хэсэгт цөмрөл нуралд өртөхгүй гаргах ажлыг ХАБЭА – н ажилтан, ашиглалтын инженер хариуцан ажилаана.	Гал ашиглалтын итвэхтэй бүсэд гарвал ашиглалтын итвэхгүй бүсээс карьеруу орсон налуу траншейгаар галын голомтонд очино голомтонд очихдоо гал хаваж шатсан байх болзошгүй тул нурам цөмөрч аюулд өртөхөөс өөрийгөө болон бусдыгаа хамгаалж сонор сэрэмжтэй ажиллах.	Гал гарсан бүсийг тогтоож аюулд өртсөн ажилтануудыг аврах, аюулгүй бүсэд хүргэсэний дараа галын голомтыг унтраах ажилд орно. Анхаарах зүйл: Гал хаваж шатсан байх магадлалтай тул нурам цөмрөх аюулаас болгоожлох	Хүрээлэн буй орчинд гал түймэр гарвал түүний цар хүрээнээс хамаарч гарах зардал нь өөр өөр байх тул Баялаг-Орд ХХД-н Гүйцэтгэх захирал Д.Ганбаатар-н тушаалаар шууд гаргаж ажиллахаар төлөвлөлөө.
2.	Баянхонгор аймгийн ОБ – н газрын аврах ангийн ажилтанууд болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.	Уурхайн инженер				
3.	Уурхайн ус таталт болон гэрэлтүүлгийн цахилгааныг бүрэн салгана.	Уурхайн цахилгаанчин				
4.	Гал гарсан хэсэгт ажиллаж байсан ажилчидыг бүртгэнэ	ХАБЭА – н ажилтан				
5.	Гал гарсан хэсэгт болон хаваж шатсан байх болзошгүй хэсгийг тойруулан аюултай гэсэн тууз татаж харуул тавина.	ХАБЭА – н ажилтан бусад ажилчидын хамт				
6.	Галыг унтраах, таслах ажлыг зохион байгуулна.	Гүйцэтгэх захирал				

Галын аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан:

“Баялаг – Орд” ХХК – н ХАБЭА – н ажилтан Б.Баасанжаргал

Уурхайн олборлотын тоног төхөөрөмжийн Галын аюулын үед татан оролцуулах жагсаалт

Хүснэгт № 5

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр				Хүчин чадал		Ашиглалтын хугацаа			Өмчлөлийн хэлбэр	Техникийн бэлэн байдал
	Төрөл	Марк	Загвар	Үйлдвэрлэсэн улс	Хэмжих нэгж	Хэмжээ	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтанд өгсөн он	Ашиглалтын хугацаа		
1	Эксковатор	HYUNDAI	290LC-7A	Япон	м3	1.5	2010	2013	11	Өөрийн	сайн
2	Эксковатор	HYUNDAI	290LC	Япон	м3	1.3	2002	2010	14	Өөрийн	дунд
3	Автосамосвал	NORTHBE NZ	Өөрөө буулгагч	Хятад	м3	20	2010	2013	11	Өөрийн	сайн
4	Автосамосвал	HOWO	Өөрөө буулгагч	Хятад	м3	18	2010	2012	12	Өөрийн	сайн
5	Автосамосвал	HOWO	Өөрөө буулгагч	Хятад	м3	18	2004	2008	16	Өөрийн	сайн
6	Автосамосвал	HOWO	Өөрөө буулгагч	Хятад	м3	18	2010	2013	11	Өөрийн	сайн
7	Бульдозер	SHANTUI	T-130	Хятад	м3	120	2010	2013	11	Өөрийн	
8	Утгуурт ачигч	VOLVO	ZL-50E	Хятад	м3	3	2006	2008	16	Өөрийн	дунд
9	Үйлчилгээний машин	PIKAB	Хагас ачаа	Япон			2010	2010	14	Өөрийн	сайн

Жагсаалт гаргасан: “Баялаг – Орд” ХХК

Өвөр-Чулуутын уурхайн ХАБЭА-н ажилтан Б.Баасанжаргал

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шиэжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал /төг/	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар	Кемп, Гадаад овоолго тус тус	2024 оны 8,10-р сард 2 цэг дээр	2	250 000	250 000*2 ширхэг дээж = 500 000	Баянхонгор аймгийн УЦУОШТ лабораториор шинжлүүлнэ.	MNS 4585:2016 стандартыг баримтлана.
2.	Хөрс	Шатахуун түгээгүүр, Гадаад овоолго дээр	2024 оны 8,10-р сард 2 цэг дээр	2	100 000	100 000*2 ширхэг дээж =200 000	Улаанбаатар хотноо итгэмжлэгдсэн лабратороор шинжлүүлнэ	MNS 5850:2008 стандартыг баримтлана
3.	Ус /унд ахуйн/	Баянхонгор аймгаас зөөж хэргэлэнэ.	Унд ахуйн усыг Баянхонгор аймнаас зөөж хэрэглэнэ.		-	-	Тайлбар хэсэгт ундны усыг Баянхонгор аймагас зөөж хэрэглэх талаар тусгалаа.	
	Нийт			4		800 000		

Тайлбар:

Орд орчмын усанд шинжлэх ухааны академи геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид хийлгэсэн шинжилгээний үр дүнгээр энэхүү ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн,

давсархаг, хатуу бохирдолтой ус гэсэн тул ахуйн хэрэглээнд шууд хэрэглэхэд тохиромжгүй юм. Иймээс ахуйн хэрэглээний усыг Баянхонгор аймгаас зөөж хэрэглэхээр төсөлд тусгав.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг – Орд” ХХК

Өвөр – Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

**АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Уридчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь		Хариуцах албан тушаалтан	Тайлбар
			2024 он			
			Сар			
1	2	3		4	5	
1.	Байгаль орчны аудитын зөвлөжинд заасан зөвлөмжүүдийг хийж, хэрэгжүүлэх	400 000 төгрөг	5 – 10-р сард		Байгаль орчны ажилтан Б.Баасанжаргал	Байгаль орчны хууль, дүрэм, журам холбогдох стандартууд болон бусад шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллах
2.	Баянхонгор аймаг Галуут сумын Засаг дарга, ИТХ-тай хамтран ажиллах	100 000	2024 онд		Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн Б.Баасанжаргал	Байгаль орчны хууль, дүрэм, журам холбогдох стандартууд болон бусад шаардлагуудыг мөрдлөг болгон ажиллах
Нийт		500 000				

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК

Өвөр - Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал /төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Хүргэх газар
	1	2	3	4	5	6	7
1.	Баянхонгор аймаг Галуут сумын Байгаль орчны улсын байцаагч	БОХ-3.1 хэвлэмэл хэлбэрээр	Эвдэгдсэн газар нөхөн сэргээлт	2024 оны 11-р сарын 20-нд	200 000	Байгаль орчны ажилтан Б.Баасанжаргал	Баянхонгор аймаг Галуут сумын Байгаль орчны байцаагч
2.	Баянхонгор аймаг БОАЖГ-т	2024 оны БОМТ - ний биелэлтийг дүгнүүлэх, нөхөн сэргээлт хүлээлгэн өгөх	2024 оны менежментийн төлөвлөгөөний биелэлт, нөхөн сэргээлт	2024 оны 11-сарын 20-нд	300 000	Байгаль орчны ажилтан Б.Баасанжаргал	Баянхонгор аймаг БОАЖГ, Галуут сумын Байгаль орчны байцаагч, www.eic.mn-нд шивэх
	Нийт				500 000		

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК

Өвөр - Чулуутын уурхайн Байгаль орчны ажилтан Д.Нямсүрэн

АРВАН ТАВ. “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ийн индэр дээрээс дэлхийн нийтэд хандан Монгол Улс 2030 он гэхэд тэрбумаар тоологдох мод тарьж, ургуулах зорилт дэвшүүлээд байгаагаа мэдэгдэж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар эхлүүлсэн.

“Тэрбум мод” тарьж ургуулах нь зөвхөн дан ганц байгаль орчны салбарын ажил биш, монгол хүн болгон сэтгэл зүрхээрээ оролцох ёстой ажил юм.

Иймээс “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн салбарынханч гэсэн мод тарих хөдөлгөөнийг дор бүрнээ өрнүүлж эхлээд байна.

Уг хөдөлгөөнийг дэмжиж манай компани өөрийн тусгай зөвшөөрөл бүхий талбай, кемпийн ногоон байгууламж дээр 2000 оноос хойш 500 гаран суулгац тарьсанаас 300 ш мод ургацын явц сайн байна, энэ бутан дээрээ нэмж 2024 онд 100.0 ширхэг чацарганы суулгац мод тарьж уг хөдөлгөөнд хувь нэмэр оруулахаар төлөвлөлөө.

Зардал болон тоо ширхэгийг мөн тухайн төлөвлөгөөний 16-р хуудас **БИОЛОГИЙ ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**-нд оруулж өглөө.

Хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан: “Баялаг - Орд” ХХК

Гүйцэтгэх захирал Д.Ганбаатар

АРВАН ЗУРГАА. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- 16.1. Төслийн техник эдийн засгийн үндэслэл
- 16.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
- 16.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
- 16.4. Төслийн 2024 оны ашиглалтын үйл ажилгааны төлөвлөгөө
- 16.5. Уул уурхайн салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2008
- 16.6. Байгаль орчин аялал жуулчлалын яамны вэб сайт www.eic.mn
- 16.7. Байгаль орчины менежментийн төлөвлөгөө боловсоруулах шинчлэгдсэн журам

**“БАЯЛАГ ОРД” ХХК -НИЙ 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮГНЭХ ХУУДАС**

2023.12.03


Дугаар: 02

Номгон

1. **Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр:** “Баялаг орд” ХХК
2. **Төслийн байршил:** Баянхонгор аймаг, Галуут сум, Сүмбэрийн 2 дугаар баг, Өвөр чулуут
3. **Тусгай зөвшөөрлийн дугаар:** МУ - 000222
4. **Огноо:** 2023.12.03

Д/д	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд Бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо Үнэлгээ	Үнэлсэн онооны энгийн арифметик дундаж оноо	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	16.6	3 ажил тусгасан 1 ажил хийгдээгүй.
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	30	1 ажил тусгасан 1 ажил бүрэн хийгдсэн.
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	1 ажил тусгасан 1 ажил бүрэн хийгдсэн.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	0**	Ажил төлөвлөгдөөгүй
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	1 ажил тусгасан 1 ажил бүрэн хийгдсэн.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	2 ажил тусгасан 1 ажил бүрэн хийгдсэн.
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	4	3 ажил тусгасан 2 ажил бүрэн, 1 ажил дутуу хийгдсэн
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	5	1 ажил тусгасан 1 ажил бүрэн хийгдсэн.
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	2 ажил тусгасан 2 ажил бүрэн, хийгдсэн
		Нийт оноо 100	90.6	


Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэрийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Өвөр чулуут” нэртэй газарт МҮ -000222 хүрэн нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Баялаг орд” ХХК -ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 20 -ний өдрийн А/22 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ⁹⁰⁶ гүйцэтгэлтэйгээр дүгнэлээ. Цаашид тус компани нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлыг бүрэн хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Э.Ганзориг

Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал хариуцсан газрын ахлах мэргэжилтэн
Б.Наранбаатар

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын Улсын байцаагч  Т.Мөнхжаргал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн  Б.Зүгдоржав

Галуут сумын байгаль хамгаалагч /БОХУБ/


 С.Бадгаа

Галуут сумын Байгаль хамгаалагч  Д.Мөнхсайхан

Иргэний төлөөлөл  М.Баяртогтох

Хүлээн зөвшөөрсөн:

“Баялаг орд” ХХК – ны гүйцэтгэх захирал

 Д.Ганбаатар



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮЛЭЭН
АВСАН ТУХАЙ АКТ

2023.12.03

№ 02

Номгон


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 06 -ний өдрийн А/439 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны 01 сарын 20 – ний өдрийн А/22 дугаар захирамжаар томилогдсон тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх, нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах комисс, Баянхонгор аймгийн Галуут сумын Сүмбэрийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Өвөр чулуут” нэртэй газарт хүрэн нүүрсний олборлолтын чиглэлээр МУ – 000222 тусгай зөвшөөрөл бүхий “Баялаг орд” ХХК -ны 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийн байдалтай газар дээр нь танилцав. Тус компани нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 0,7 га, биологийн нөхөн сэргээлтийг 0 га, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд “Өвөр чулуут” нэртэй газарт 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөсөн байна.

“Баялаг орд” ХХК нь аймгийн нөхөн сэргээлтийг хүлээж авах байнгын комисст төлөвлөгөөт техникийн нөхөн сэргээлтийг 1.18 га, биологийн нөхөн сэргээлтийг 0 га, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2.4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг хийж танилцуулав.

Комиссын шийдвэр:

“Баялаг орд” ХХК нь Галуут сумын Сүмбэрийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт “Өвөр чулуут” чулуут нэртэй газар техникийн нөхөн сэргээлт хийсэн байдалтай ажлын хэсэг газар дээр нь үзэж танилцлаа. Тус компаний хийсэн төлөвлөгөөт 1.18 га, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2.4 га талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлт нь “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917:2008 техникийн ерөнхий шаардлагыг хангаж байна гэж үзэв.

Хавсралтанд заагдсан солбицол бүхий 3.58 га техникийн нөхөн сэргээлт.

Ажлын хэсгийн ахлагч: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэн  Э.Ганзориг




Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудал хариуцсан газрын хулаа мэрэгжилтэн

Б.Наранбаатар

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын Улсын байцаагч  Т.Мөнхжаргал

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн  Б.Зүгдоржав

ГХБХБГ -ын суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Ганзориг

Галуут сумын байгаль хамгаалагч /БОХУБ/  С.Бадгаа


Галуут сумын Байгаль хамгаалагч  Д.Мөнхсайхан

Галуут сумын иргэний төлөөлөл  М. Баяртогтох

Хүлээн зөвшөөрсөн:


“Баялаг орд” ХХК – ны гүйцэтгэх захирал

Д.Ганбаатар






БАЯЛАГ ОРД ХХК-НЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖИЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙСЭН 1,18 ГА ТАЛБАЙ



2
1
3



БАЯЛАГ ОРД ХХК-НЫ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН 2,4 ГА ТАЛБАЙ



1	100	7	44.1	46	22	36.8
2	100	7	45.29	46	22	41
3	100	7	53.09	46	22	40.5
4	100	7	52.57	46	22	35.9

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар	2	0	0	7	1	2	6
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Баялаг-Орд ХХК						
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл	Баянхонгор			6 4			
Сум, дүүрэг	Галуут			3 4			

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	0	0	2	2	2
Тусгай зөвшөөрлийн талбай, га	72							
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	1	9	9	7	0	5	0	1
Ашигт малтмалын төрөл	Хүрэн нүүрс							
Ашиглалтын төрөл	Ил ашиглалтын систем							

1. Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт маягтаар ирүүлнэ.

2. Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн газарт цахим хэлбэрээр ирүүлнэ.

3. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн газар нь мэдээг хянаж, нэгтгээд 2 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчны мэдээллийн төвд цахим хэлбэрээр ирүүлнэ.

4. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээг хянаад 2 дугаар сарын 25-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгжид цахим хэлбэрээр ирүүлнэ.

5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгж нь мэдээг хянаж, нэгтгээд 3 дугаар сарын 10-ны дотор статистик хариуцсан нэгжид цахимаар болон маягтаар ирүүлнэ.

6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик хариуцсан нэгж нь мэдээг хянаж, 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахимаар болон маягтаар ирүүлнэ.

3. УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд
				(ашиглалт хийсэн)
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	х	х
Ашигласан талбай	2	га	20.75	1
	3	мян.м ³	4046.25	195
Хаягдал чулуулгийн овоолго	4	га		
	5	мян.м ³		
Хөрсний овоолго	6	га	1.7	
	7	мян.м ³	136	
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	8	га	1.8	
Бусад	9	га		

4. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн асуудал хариуцсан нэгжид	
				Техникийн	Биологийн
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	19	14	5
	11	мян.м ³	3315	3315	х
Тайланд онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	0.7	0.7	
	13	мян.м ³	45.4	45.4	х
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр14> мөр16, мөр15>мөр17	14	га	18.44	12.1	6.34
	15	мян.м ³	2359.5	2359.5	х
Тайланд онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	0.6	1.1	0.6
	17	мян.м ³	71.5	71.5	х
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал, мөр18>мөр19	18	мян.төг	154295	102450	51845
	19	мян.төг	17845		17845
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20>мөр21	20	мян.төг	16500	х	х
	21	мян.төг	3150	х	х
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр22> мөр23	22	мян.төг	388290	х	х
	23	мян.төг	5030	х	х

ЭЗЭГ ҮЙЦЭТГЭХ
ТАМГА

"Баялаг - Орд" ХХК - н Гүйцэтгэх захирал Д.Ганбаатар /

Нягтлан бодогч Б.Нямсүрэн /


2023 оны 11 - р сарын 30 - ны өдөр

Handwritten signature and date




БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛААР ЗӨВЛӨХ, НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ
"ЭХОПЛАНЕТ" ХХК

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ
"ӨВӨРЧУЛУУЛТЫН" НҮҮРСНИЙ ОРД АШИГЛАХ" ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН
НЭМЭЛТ ТОДОТГОЛ



БАТЛАВ:
БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г. ЭНХМӨНХ

ШҮҮМЖ ХИЙСЭН:
БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ

B. Batbayar

Б. БАТБАЯР

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ
"ӨВӨРЧУЛУУЛТЫН" НҮҮРСНИЙ ОРД АШИГЛАХ" ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН
НЭМЭЛТ ТОДОТГОЛ**

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: "БАЯЛАГ ОРД" ХХК

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН:

"ЭХОПЛАНЕТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л. ОРГИЛ



ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

"БАЯЛАГ ОРД" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Д. ЧУЛУУНБААТАР



УЛААНБААТАР ХОТ 2021 ОН